

2011-04-11

Монголын улс төрчид ард түмнээ цөмийн хаягдлаар хордуулахаар аль эртнээс санаархаж байж дээ...

Монгол улс гадныхны цөмийн хог хаягдлыг булшлах цэг болгохоор дээдсүүд гэрээ хэлэлцээр хийгээд эхэлснийг Америкийн сэтгүүлээс мэдсэн Монголын ард түмэн ихээр цочирдож байна. Гэнэн зарим нь “Төр засаг маань 4 сарын 1 гээд биднийгээ хуурч байгаа байлгүй” гэж ч байх шиг, долигнуурууд нь болохоор “АНУ юм гуйхаар нь манайхан шууд үгүй гэж чадахгүй байгаа байлгүй, яалаа гэж манай улс төрчид тийм шийдвэр гаргахав” гээд нөгөө хэдийгээ өмөөрч байх...

Тэгвэл Монголд цөмийн хог хаягдал хаях асуудал хэдхэн сарын өмнө эхэлсэн ч биш юм байна. Аль дээр 2004 онд л Тайваньтай энэ талаар хэлэлцэж байжээ. Бүр тогтоол төлөвлөсөн нь 50-50% санал аваад батлагдаагүй буцсан ч гэх шиг...



Франц улс цөмийн хог хаягдлаа ОХУ-д булшилж байгааг эсэргүүцэгчид Москва дахь Францын ЭСЯ-ны гадаа.

Энэ талаар тэртээ 2009 оны 6 сард УИХ-ын гишүүн Д. Энхбат “Өдрийн Сонин”-ы сурвалжлагч Б. Жавзмаад ярилцлага өгч байсныг олж дор тавилаа.

Монгол цөмийн хаягдлыг булшилдаг орон болж хувирах магадлал өндөр

Манай улс цөмийн эрчим хүчний түүхий эд ураны 63 мянган тонн нөөцөөрөө дэлхийд 15-д ордог. 1990-ээд оноос өмнө геологичид тогтоосон 1.2 сая тоннын нөөц байх магадлалтай гэсэн нь батлагдвал дэлхийд айргийн тавд орно.

Алтнаасаа ашиг хүртэх бодлого “Өөрийн нохой идэхээр, хүний нохой ид” гэсэн урвуу хувирбарын жишээг “Бороо гоулд” компантай хийсэн анхны тогтвортой байдлын гэрээ харуулсан.

Одоо УИХ уранаа зарж мөнгө олох, бүр цаашлаад эрчим хүчний эх үүсвэрээ цөмийн энергээс гаргадаг үйлдвэртэй болох бодлого батлахаар хэлэлцэж байгаа.

Уран бол энгийн нэг ашигт малтмал биш, буруугаар ашиглавал дэлхийг сөнөөх чадалтай эд. Цөмийн зэвсэг, цөмийн аюулын тухайд хүн төрөлхтөн мартагын аргагүй сургамжийг Японы Хирошимод хаясан атомын бөмбөг, Украины Чернобылын атомын станц дэлбэрэлтээс авсан.

Төрөөс цацраг идэвхит ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг ураны хэрэглээ, үнэ өндөр байгаа өнөө цагт батлах нь зүйтэй гэж УИХ-ын гишүүдийн олонх үзэж байгаа юм. Харин бодлогын баримт бичигт “цөмийн хаягдлыг хадгалах, боловсруулах байгууламж барих” гэсэн өгүүлбэр нь анхаарал татлаа.

Ураны бодлогын талаар УИХ-ын гишүүн Д.Энхбат эсрэг байр суурьтай байна.

-Ураны лицензийн бодлого анхнаасаа замбараагүйтсэн. Лицензийг хувь хүн арав хориор нь халааслаад зарна гээд явж байна. Лицензийг цэгцэлчихээд бодлого ярих хэрэгтэй. Бодлогын баримт бичигт цөмийн эрчим хүч ашиглах гэх мэт сайхан мөрөөдөл олон бий. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хайж, нээсэн ордуудаа гадаад, дотоодын хувь хүмүүст алдчихсан, замбараагүй вед ураны бодлого гэж гоё зүйл ярих утгагүй.

-Ураны ашиг орлого бидэнд хэрэгтэй биш гэж үү?

-Авлигад идэгдсэн засаг төрд ураны бизнесийг хариуцуулж болох уу. Цаг нь болоогүй. Юун уран, цианитаа цэвэрлэж чадахгүй байгаа шүү дээ. Бороо гоулд, Цайрт минералын гэрээг яаж хийлээ. Юу ч хожоогүй. Манай Засгийн газар ядуураад гэрийн бүх хогшил тавилгаа зарж байгаа айл шиг байна. Асуудал урандаа биш, засаглалдаа байна. Согтуу хүнд машин бариулж болохгүй биз дээ.

-Бодлогын баримт бичигт ураны хаягдал хадгалах тухай өгүүлбэр байсан. Үүнийг юу гэж ойлгох вэ?

-Өмнө нь цөмийн хаягдлыг булж болно гэсэн тогтоолын төсөл орж ирсэн. Гишүүд тавь, тавин хувиар тэнцээд энэ төслийг шийдэлгүй орхисон. Монгол цөмийн эрчим хүчийг хөгжүүлээд атомын цахилгаан станцыг барихаасаа өмнө цөмийн хаягдлыг булшилдаг орон болох магадлал өндөр. Яагаад гэвэл манайхны хяналт сул, өргөн уудам нутагтай, сул мөнгө маш их орж ирдэг.

-Бусад орнууд хаягдал авдаг гэсэн шүү дээ?

-Дэлхийн бvх орон хаягдал авахаас татгалздаг. Өндөр төлбөрөөр, хадгалалт хамгаалалтын өндөр нөхцлөөр хадгалдаг цөөхөн орон бий. Манайх гялгар уут, хогоо цэгцэлж чадахгүй байгаа улс, юун цөмийн хаягдал агуулах. Цөмийн хаягдал орчин тойрноо олон жил хордуулж байдаг аюултай бодис. Хаягдал нь уранаас илүү хортой. Цөмийн хаягдлын хор хүний генийг хордуулдаг. Уран олборлох, цөмийн хаягдал байршуулах хоёр өөр ажил. Манайх ураны түүхий эдийнхээ хаягдлыг ч буцааж авах ёсгүй. Дэлхийн бусад орон вйлдвэрлэл вйлчилгээгээ дээд зэргээр хөгжүүлж сайхан амьдарч байхад бид яахаараа хамаг юмаа зарж, хордуулж амьдрах ёстой юм бэ. Улс орон ийм замаар явбал мөхдөг гэдгийг Африкийн орнуудын жишээ харуулсан шүү дээ.

Эх сурвалж: <http://enkhbatd.wordpress.com/2009/07/10/авлигад-идэгдсэн-засаг-төр-ураны-бизн/>